



АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ нь даатгуулагчид учирсан эрсдэлийг бууруулах, хуваалцах, ажилгүй болсон даатгуулагчийг дараагийн ажилд орж орлогтой болох хүртэлх хуулиар тогтоосон хугацаанд нийгмийн даатгалын сангаас амьдралын баталгааны эх үүсвэр болгон олгож буй мөнгөн хөрөнгө юм.

ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС ДАРААХ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛНӨ

Ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ	0.2%
Албан журмын даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ	0.2%

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ



Ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчид дор дурдсан тэтгэмж, зардлыг олгоно. Үүнд: Ажилгүйдлийн тэтгэмж Мэргэжил олгох, давтан сургалтын зардал *Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх:* Даатгуулагч нь дараах болзлыг хангасан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх анх үүснэ.

- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр гарахаас өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн.

Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сараас доошгүй хугацаагаар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.

Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг шимтгэл төлсөн сүүлийн 3 сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос дараах хувь, хэмжээгээр бодож олгоно:

Шимтгэл төлсөн хугацаа	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	45%
5-10 хүртэл жил	50%
10-15 хүртэл жил	60%
15 ба түүнээс дээш жил	70%

Ажилгүйдлийн тэтгэмж олгох олгох хугацаа:

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрийн хугацаанд олгоно.

Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт илгээх:

Даатгуулагч Та ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ <https://daatguulagch.ndaatgal.mn/> цахим хаягаар нийгмийн даатгалын байгууллагад илгээж болно.

Бүрдүүлэх бичиг баримт:

- Тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл;
- Ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр;
- Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт.